

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан орон нутгийн зам, тээвэр ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2023/6/НА-СТА-ОНА

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>  Дархан-Уул аймаг 2023 он	Дархан Уул аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 7037-3089, 9902-3869 Цахим хаяг: <a href="mailto:munkhbayrsh@audit.gov.mn">munkhbayrsh@audit.gov.mn</a>  Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 9903-6806 Цахим хаяг: <a href="mailto:batsurenu@audit.gov.mn">batsurenu@audit.gov.mn</a>  Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 7037-3089 Цахим хаяг: <a href="mailto:battsetsgs@audit.gov.mn">battsetsgs@audit.gov.mn</a>  Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Си Эс Ай Аудит ХХК Захирал: М.Сэвжидмаа Утас: 70001981 Цахим хаяг: <a href="mailto:sevjidmaa@csiaudit.mn">sevjidmaa@csiaudit.mn</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Contents

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b> .....	5
<b>2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан</b> .....	5
<b>2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан</b> .....	6
<b>2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан</b> .....	7
<b>2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан</b> .....	8
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	11
<b>3.1 Төлбөрийн акт</b> .....	11
<b>3.2 Зөвлөмж</b> .....	11
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	12
<b>4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл</b> .....	12
<b>4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	13

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДОНЗТ	Дархан орон нутгийн зам тээвэр
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.15 № 470

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрчис Ойл” ТӨХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дархан орон нутгийн зам, тээвэр ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага батлагдсан төсвөөс 3 орон тоо хэмнэж, цалин, урамшуулал 15.8 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 12.7 сая төгрөг, нормын хувцас, хөдөлмөр хамгаалал хэрэгсэл 1.7 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 1.2 сая төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2022 онд “ДОНЗТ” ОНӨААТҮГ-ын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг” тайлант оны нийт орлогыг 403.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 403.1 сая төгрөгөөр, 0 төгрөгийн ашиг/ алдагдалтай ажиллахаар баталж, мөн Дархан-Уул аймгийн ИТХ 2022 оны 25 дугаар тогтоолоор тодотгол хийж нийт орлого 453.1 сая төгрөг, нийт зардлыг 453.1 сая төгрөгөөр байхаар эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөг баталж, гүйцэтгэлээр 551.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 444.8 сая төгрөгийн зардал гарган, 92.1 сая төгрөгийг төрийн сан руу төвлөрүүлэн, кассанд 14.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Дархан орон нутгийн зам, тээвэр ОНӨААТҮГ-ын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	11,375,110.47	14,424,020.04
1.1.2	Дансны авлага	8,890,931.92	9,343,316.12
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	12,617,491.29	113,544,959.14
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10		-	-
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	32,883,533.68	137,312,295.30
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	55,006,365,220.20	77,332,635,714.99
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	2,980,916.60	2,877,855.73
1.2.9		-	-
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	55,009,346,136.80	77,335,513,570.72
1.3	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	55,042,229,670.48	77,472,825,866.02
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>	-	-
2.1.1	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,643,097.70	7,763,279.57
2.1.1.3	Татварын өр	2,608,639.19	7,728,821.06
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	34,458.49	34,458.49
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	2,643,097.70	7,763,279.57
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	2,643,097.70	7,763,279.57
	<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
2.3	<b>Өмч</b>	-	-
2.3.1	-төрийн	22,471,303,981.29	22,471,303,981.29
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14,905,686,103.25	14,905,686,103.25
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	35,064,157,802.50	62,736,523,962.50
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(17,401,561,314.26)	(22,648,541,460.59)
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	55,039,586,572.78	77,465,062,586.45
2.4	<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	55,042,229,670.48	77,472,825,866.02

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	392,894,376.36	500,672,978.44
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
<b>3</b>	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>392,894,376.36</b>	<b>500,672,978.44</b>
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	260,075.00	89,542,825.89
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	4,763,542,225.81	5,684,069,930.92
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	1,848,265.42	153,036,019.74
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг ( алдагдал)	-	-
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(4,372,236,039.87)</b>	<b>(5,246,890,146.33)</b>
19	Орлогын татварын зардал	-	-
20	<b>Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(4,372,236,039.87)</b>	<b>(5,246,890,146.33)</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(4,372,236,039.87)</b>	<b>(5,246,890,146.33)</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
<b>24</b>	<b>Нийт дэлгэрэнгүй орлогын дүн</b>		
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	-	-

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	22,471,303,981.29	14,905,686,103.25	17,379,737,218.00	(13,030,509,117.85)	41,726,218,184.69
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	(4,372,236,039.87)	(4,372,236,039.87)
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	17,684,420,584.50	1,183,843.46	17,685,604,427.96
<b>2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	22,471,303,981.29	14,905,686,103.25	35,064,157,802.50	(17,401,561,314.26)	55,039,586,572.78
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(5,246,890,146.33)	(5,246,890,146.33)
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	27,672,366,160.00	-	27,672,366,160.00
<b>2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	22,471,303,981.29	14,905,686,103.25	62,736,523,962.50	(22,648,451,460.59)	77,465,062,586.45

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
1	<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
1.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>423,675,126.09</b>	<b>761,208,625.96</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	423,675,126.09	761,208,625.96
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого		352,663,171.41
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>422,175,528.75</b>	<b>758,159,716.39</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	132,631,947.91	144,699,940.59
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	38,418,070.86	41,399,951.19
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	153,977,456.26	492,889,354.32
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	49,237,253.36	2,701,639.11
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	47,738,155.01	61,377,289.16
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	172,645,35	15,091,542.02
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,499,597.34</b>	<b>3,048,909.57</b>
2	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
2.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>		
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>		
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		
3	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
3.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		
4	Валютын ханшийн зөрүү		
4.1	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>1,499,597.34</b>	<b>3,048,909.57</b>
5	<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	<b>9,875,513.13</b>	<b>11,375,110.47</b>
6	<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>11,375,110.47</b>	<b>14,424,020.04</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	429,190.1	536,996.4	107,806.30	125.1
2	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	429,190.1	444,868.9	15,678.80	103.7
3	Бараа, үйлчилгээний зардал	421,405.1	444,868.9	23,463.80	105.6
4	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	192,608.9	<b>176,785.7</b>	(15,823.20)	91.8
5	Үндсэн цалин	145,598.2	142,224.5	(3,373.70)	97.7
6	Ур чадвар	15,268.9	12,048.5	(3,220.40)	78.9
7	Улирал, урамшуулал	14,559.8	12,027.2	(2,532.60)	82.6
8	Хоол унаа	17,182.0	10,485.5	(6,696.50)	61.0
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,256.1	<b>21,656.1</b>	(600.00)	97.3
10	Байр ашиглалттай холбоотой зардал	14,576.0	<b>11,450.5</b>	(3,125.50)	78.6
11	Гэрэл цахилгаан	1,500.0	1,001.6	(498.40)	66.8
12	Түлш халаалт	2,376.0	1,671.5	(704.50)	70.3
13	Цэвэр бохир ус	360.0	389.6	29.60	108.2
14	Байрны түрээс	10,340.0	8,387.8	(1,952.20)	81.1
15	Хангамж бараа материалын зардал	183,937.1	<b>180,102.9</b>	(3,834.20)	97.9
16	Бичиг хэрэг	1,925.7	1,968.7	43.00	102.2
17	Тээвэр шатахуун	25,264.0	21,944.8	(3,319.20)	86.9
18	Сэлбэг хэрэгсэл	3,420.0	3,696.0	276.00	108.1
19	Шуудан холбоо интернетийн төлбөр	800.0	693.1	(106.90)	86.6
20	Цэвэрлэгээний материал	370.0	463.7	93.70	125.3
21	Засвар арчлалтын материал	148,421.4	149,621.4	1,200.00	100.8
22	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	300.0		(300.00)	-
23	Биеийн тамирын уралдаан тэмцээн	-	-	-	
24	Нормын хувцас, хөдөлмөр хамгаалал хэрэгсэл	3,436.0	1,715.2	(1,720.80)	49.9
25	Эд хогшил урсгал засварын зардал	1,700.0	-	(1,700.00)	-
26	Урсгал засвар	1,700.0		(1,700.00)	-
27	Томилолт зочны зардал	500.0	<b>685.0</b>	185.00	137.0
28	Дотоод албан томилолт	500.0	685.0	185.00	137.0
29	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	5,827.0	<b>4,617.5</b>	(1,209.50)	79.2
30	Аудитын төлбөр	1,425.0	1,425.0	-	100.0
31	Улсын мэдээллийн маягт хэвлэх	3,402.0	2,495.0	(907.00)	73.3
32	Төлбөр хураамж	1,000.0	697.5	(302.50)	69.8
33	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	-	
34	Бусад зардал	-		-	
35	Холбооны суваг ашигласны хөлс	-		-	
36	Нийгмийн хамгаалал	4,623.5	<b>4,597.5</b>	(26.00)	99.4
37	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тусламж	-		-	

Дархан орон нутгийн зам, тээвэр ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

38	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,623.5	4,597.5	(26.00)	99.4
39	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	
40	Өөрийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт	-	-	-	
41	Компьютер техник хэрэгсэл	-	-	-	
42	Тавилга	-	-	-	
43	Машин тоног төхөөрөмж	-	-	-	
44	НӨАТ	23,889.9	44,973.7	21,083.80	
45	Татвар хүү, торгууль	3,161.5	3,706.8	545.30	117.2
	Төвлөрүүлэх		92,127.5	92,127.50	
46	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР :	453,080.0	<b>551,420.4</b>	(98,340.40)	121.7
47	Шалган бүртгэх товчооны орлого	130,000.0	186,672.6	106,551.50	143.6
48	1 удаагийн хураамжийн орлого	260,000.0	309,652.6		119.1
49	Тээврийн орлого	4,080.0	2,392.0		58.6
50	Хүнд даацын авто машинд олгох зөвшөөрөл	9,000.0	19,515.0		216.8
51	Гэрээт ажлын орлого	50,000.0	33,188.2		66.4
52	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		14,424.0		

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2.9 сая төгрөгийн зөвлөмж өгсөн байна.

#### 3.1 Төлбөрийн акт

**Илрүүлэлт1:** Байгууллагын дотоод ажил үйлчилгээнд явж байгаа 91-76 ДАР дугаартай Соната-6 маркийн авто машины шатахууны зарцуулалтыг 100 км -т 20 л шатахуунаар тооцон 1.4 сая төгрөгийн зарлага илүү гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.5-т *"Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хууль тогтоомжид заасны дагуу авто машины шатахууныг тооцож зарцуулах, цаашид алдааг давтан гаргахгүй байх, төлбөрийн акт тогтоох.

#### 3.2 Зөвлөмж

**Илрүүлэлт1:** Тус байгууллага нь 2022 оны илүү цагийг тооцож олгохдоо 3 сарын дундаж цалингийн дунджаас бодож олгоогүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн *"Нэмэгдэл хөлс"*, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаалаар баталсан *"Дундаж цалин хөлс тодорхойлох журам"*-ын 2.2-т *"Илүү цаг, шөнийн цаг, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтны нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо тухайн ажилтны сүүлийн 3 сарын цалин хөлсөөр тооцно. Энэ тохиолдолд дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс болон байнгын бус, нэг удаагийн шинжтэй шагнал урамшууллыг оруулахгүй байж болно. Ажил олгогч, ажилтан харилцан тохиролцооноор нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс болон байнгын бус, нэг удаагийн шинжтэй шагнал урамшууллыг оруулж болно"* гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэлт:** Тус байгууллага нь 3 сарын дундаж цалин хөлсийг хууль журмын дагуу тооцож илүү цаг, шөнийн цаг, нийтээр амрах баяр ёслолын өдөр ажилласан цагийн хөлсийг үнэн зөв олгож байх.

**Илрүүлэлт:2** Тус байгууллага нь тайлант онд Хөдөлмөрийн дотоод журам, тушаал шийдвэрээр хоол унааны мөнгийг тогтоож өгөөгүй, ажиллагсад хоолны хөнгөлөлт гэж ажилласан өдөрт 2.0 мянган төгрөг сар бүр олгосон боловч 6,7,9,10,11 саруудад хоолны мөнгө гэж нийт 2.9 сая төгрөг илүү олгосон байна.

Энэ нь 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*,

**Шийдвэрлэлт:** Хөдөлмөрийн дотоод журамд хоол унааны мөнгийг тусгаж өгөх, тушаал шийдвэрийн дагуу олгох зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Байгууллагын дотоод ажил үйлчилгээнд явж байгаа 91-76 ДАР дугаартай Соната-6 маркийн авто машины шатахууны зарцуулалтыг 100 км -т 20 л шатахуунаар тооцон 1.4 сая төгрөгийн зарлага илүү гаргасан байна.	1	1,407.2	1	1,407.2		-						
2	Тус байгууллага нь ажиллагсад хоолны хөнгөлөлт гэж ажилласан өдөрт 2.0 мянган төгрөг сар бүр олгосон боловч 6,7,9,10,11 саруудад хоолны мөнгө гэж нийт 2.9 төгрөг олгосон байна.	1	2,930.0					1	2,930.0				

Дархан орон нутгийн зам, тээвэр ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

3	2022 оны илүү цагийг тооцож олгоходоо 3 сарын дундаж цалингийн дунджаас бодоогүй хөдөлмөрийн хууль зөрчсөн байна.	1	-					1	-			
	Дүн	3	4,337.2	1	1,407.2			2	2,930.0			

4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 91 мэдээллийг хугацаанд байршуулж, 58 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	-							1	-	
	Дүн	1								1		
	<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>4,337.2</b>	<b>1</b>	<b>1,407.2</b>					<b>3</b>	<b>2,930.0</b>	